



From
the People of Japan

“ӨВСНИЙ ҮНДЭС - ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ”



Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 15-р сургуулийн засварын төсөл (2019 он)

Хөтөлбөрийн танилцуулга



Дархан-Уул аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын
2-р сургуулийн засварын төсөл (2021 он)



Хөтөлбөрийн зорилго, товч танилцуулга

Өвсний үндэс - Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр нь хүний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан хөгжиж буй орнуудын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилготойгоор тухайн бүс нутгийн иргэдэд шууд ашиг тусаа өгөх харьцангуй жижиг төслүүдэд шаардлагатай санхүүжилтийг олгодог хөтөлбөр юм.

Хөтөлбөрт хамрагдах боломжтой байгууллага

- Олон улсын болон дотоодын төрийн бус байгууллага
- Орон нутгийн засаг захиргааны нэгж, эмнэлэг, сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургууль зэрэг ашгийн бус олон нийтийн байгууллага
- Хувь хүн болон аливаа ашгийн төлөө байгууллага хамрагдах боломжгүй

Хамрах салбар хүрээ, төслийн жишээ

Монгол улсад хэрэгжиж буй төслүүдийн гол салбарууд:

- Анхан шатны боловсролын салбар: Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн засвар болон өргөтгөлийн ажил
- Эрүүл мэндийн салбар: Эмнэлгийн барилга байгууламжийн засвар, тоног төхөөрөмж нийлүүлэлт
- Нийгмийн халамж үйлчилгээ: Аймаг, сум, дүүргийн усан хангамж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төсөл
- Гамшгаас урьдчилан сэргийлэх салбар: Японы орон нутгийн засаг захиргаанаас хандивласан түргэн тусламж болон гал унтраах машины тээврийн зардал

Санхүүжилт авах боломжит хэмжээ

Нэг төсөлд олгох санхүүжилтийн боломжит хэмжээ: 10 сая иен хүртэл
“Өвсний үндэс - Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж”-ийн хөтөлбөр нь Монгол улсад 1990 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 33 жилийн хугацаанд Улаанбаатар хотын 9 дүүрэг болон 21 аймагт нийт 594 төсөл (2022 оны эцсийн байдлаар) хэрэгжүүлж, 45,148,240 ам.долларын буцалтгүй тусламж үзүүлээд байна.

Сайн байна уу?

Би бол Кусано эңко(муур).
Намайг “Өвсний үндэс”
буцалтгүй тусламжийн 30
жилийн ойг тохиолдуулан
албан ёсны маскот дүрээр
бүтээсэн юм. Би гартаа өвс
бариад дэлхийн өнцөг
булан бүрт инээмсэглэлийг
түгээдэг.



KUSANONEKO

Надтай холбоо
барихыг хүсвэл дараахь
хаягаар холбогдоорой.

www.mn.emb-japan.go.jp
(976)-7000-0776
kusanone.mongolia@ul.mofa.go.jp



ХЭНТИЙ АЙМАГ, ХЭРЛЭН СУМ

Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн засварын төсөл (2020 он)



ЗАСВАР

Хэнтий аймгийн Хэрлэн сумын уламжлалт анагаах ухааны эмнэлэг нь 1992 онд ашиглалтанд орсноос хойш засвар хийгдээгүй бөгөөд эмнэлгийн барилга нь хуучирч муудсан, мөн 2020 оны 6 сард хүчтэй аадар бороо, мөндөр орсноос дээвэр нь цоорч дусаал гоожиж болсон. Уг төслийг хэрэгжүүлснээр

эмнэлгийн орчин нөхцөл сайжирч, 3,600 үйлчлүүлэгч, 2,000 хэвтэн эмчлүүлэгч болон 21 эмч ажилчдад шууд ашиг тусаа өгсөн.



ЗАВХАН АЙМАГ, УЛИАСТАЙ СУМ

Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн засварын төсөл (2021 он)



ЗАСВАР

Завхан аймгийн Улиастай сумын нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн барилга нь удаан хугацааны ашиглалтын улмаас хуучирч муудан, цахилгаан шугамын гэмтэл, цонхны битүүмжлэл алдагдах, дээврээс дусаал гоожиж зэрэг нь 9,000 үйлчлүүлэгч, 2,000 хэвтэн эмчлүүлэгч болон 22 эмч ажилчдын аюулгүй

байдал, эрүүл ахуйд ихээхэн хэмжээний хүндрэл учруулж байсан. Энэхүү төслийн хүрээнд иж бүрэн засвар хийгдсэнээр эмчилгээний орчин сайжрахын зэрэгцээ бүс нутгийн эмнэлгийн тусламж үйлчилгээ болон эрүүл ахуйн нөхцөл сайжирсан.





ТӨВ АЙМАГ, ЗУУНМОД СУМ

Хүмүүн цогцолбор сургуулийн засварын төсөл (2021 он)



ЗАСВАР

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн хичээлийн А байр нь 1986 онд ашиглалтанд орсноос хойш их засвар хийгдээгүйн улмаас байнга дусаал гоожих зэргээр барилга байгууламж нь ихэд хуучирч муудсан бөгөөд уг нөхцөл байдал нь сургалтын аюулгүй, таатай орчныг бүрдүүлэхэд

ихээхэн хүндрэл учруулж байсан. Уг төслийг хэрэгжүүлснээр тус хичээлийн байрны сургалтын орчин сайжирч, 1,300 сурагч болон багш ажилчдад шууд ашиг тусаа өгсөн.



УВС АЙМАГ, ЗҮҮНГОВЬ СУМ

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр болон гал тогооны байрны засварын төсөл (2021 он)



ЗАСВАР

Увс аймгийн Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр 1987 онд ашиглалтанд орсноос хойш их засвар хийгдээгүйн улмаас барилга байгууламж ихэд хуучирч муудан моралийн элэгдэлд орж, сурагчид эрүүл ахуй, аюулгүй байдлын хувьд шаардлага хангахгүй нөхцөлд амьдарч байсан.

Уг төслийг хэрэгжүүлснээр тус дотуур байрны амьдрах, суралцах орчин сайжирч, 194 сурагч, 10 багш ажилчдад шууд ашиг тусаа өгсөн.





ДУНДГОВЬ АЙМАГ, САЙНЦАГААН СУМ

3-р цэцэрлэгийн засварын төсөл (2020 он)



ЗАСВАР

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3-р цэцэрлэг 1985 онд ашиглалтанд орсноос хойш их засвар хийгдээгүйн улмаас барилга байгууламж нь ихэд хуучирч муудсан бөгөөд сургалтын орчны хувьд эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй нөхцөлд байсан. Уг төслийг хэрэгжүүлснээр тус цэцэрлэгийн

сургалтын орчин сайжирч, 215 хүүхэд, 29 багш ажилчдад шууд ашиг тусаа өгсөн.



БУЛГАН АЙМАГ, ХИШИГ-ӨНДӨР СУМ

Цэцэрлэгийн засварын төсөл (2021 он)



ЗАСВАР

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн барилга ашиглалтанд орсноос хойш их засвар хийгдээгүйн улмаас хуучирч муудан, дэврээс байнга дусаал гоождог нь сургалтын үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл учруулж байсан. Уг төслийг хэрэгжүүлснээр тус цэцэрлэгийн эрүүл, аюулгүй орчин сайжирч,

тус цэцэрлэгт сурч хүмүүждэг 125 хүүхэд, 21 багш ажилчдад шууд ашиг тусаа өгсөн.





ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ, ЦОГТ СУМ

Баянтоорой тосгоны цэцэрлэгийн өргөтгөлийн төсөл (2021 он)



ӨРГӨТГӨЛ

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны цэцэрлэг нь хүчин чадлаасаа 2 дахин олон хүүхэдтэй хичээллэдэг байсан тул нэмэлт гэр барьж, өвлийн улиралд тухайн гэр цэцэрлэгт гал түлж дулааны асуудлыг зохицуулдаг байсан нь хүүхэд багачууд галд түлэгдэх эрсдэлийг бий болгож байсан.

Энэхүү төслийн хүрээнд өргөтгөлийн байр баригдсанаар 105 хүүхэд болон 15 багш ажилчид илүү аюулгүй, тохилог орчинд сурч боловсрох боломжоор хангагдсан.



УЛААНБААТАР ХОТ, НАЛАЙХ ДҮҮРЭГ

Худгийн барилгын ажлын төсөл (2020 он)



ХУДАГ
БАРИХ

Налайх дүүргийн 1,3,4,7,8-р хороонд байрлах 6 худагны барилга хуучирсан, ус агуулах сав зэвэрч, түгээж буй уснаас эвгүй үнэр, амт мэдрэгдэх болсон зэргээс үүдэн уг худагнууд эрүүл ахуйн шаардлага хангахгүй нөхцөл байдалтай байсан. Энэхүү төслийн хүрээнд 6 худгийн барилгыг шинээр барин, эрүүл ахуйн

шаардлага хангасан ундны цэвэр усыг түгээж мөн хэрэглээний халуун усаар 24 цагийн турш үйлчлэх боломжтой болсноор тус дүүргийн 7,700 иргэд (2,257 өрх) шууд ашиг тусыг хүртэж байна.





УЛААНБААТАР ХОТ


Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо ТББ-д тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл (2019 он)



ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ

Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо нь харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан бүх төрлийн ном, сурах бичгийг брайль үсгээр хэвлэдэг цорын ганц байгууллага юм. Тус холбоо нь 3 ширхэг брайль хэвлэх төхөөрөмжтэй ба, эвдрэл гэмтлээс шалтгаалан хэрэгцээт ажлын тал гаруй хувийг хэвлэж


гүйцэтгэдэг байв. Энэхүү төслийн хүрээнд брайль хэвлэх төхөөрөмж 5, програм хангамж 5, брайль хэвлэлийн дэлгэц 8 ширхэгийг тус холбоонд хандивласнаар тус холбооны брайль үсгээр хэвлэх техникийн чадамж 2 дахин нэмэгдэж, Монгол Улсын харааны бэрхшээлтэй 16,800 иргэдэд шууд ашиг тусаа өгсөн.



2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСЛҮҮД

- 📌 Улаанбаатар хотын Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвд эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл
- 📌 Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын төсөл
- 📌 Баянхонгор аймгийн Бууцагаан сумын цэцэрлэгийн засварын төсөл
- 📌 Хөвсгөл аймгийн Рашаант сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын төсөл
- 📌 Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймаг, Төв аймагт Хөдөө аж ахуйн дрон нийлүүлэх төсөл
- 📌 Монгол Улсын дөрвөн аймагт гал түймэр унтраах автомашиныг дахин ашиглах төсөл
- 📌 Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын цэцэрлэгийн засварын төсөл
- 📌 Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн засварын төсөл
- 📌 Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын 60-р сургуулийн засварын төсөл
- 📌 Архангай аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын төсөл
- 📌 Хавдар Судлалын Үндэсний Төвийн цэвэр ус түгээх системийн засварын төсөл
- 📌 Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 113-р цэцэрлэгийн засварын төсөл

“ӨВСНИЙ ҮНДЭС” ХӨТӨЛБӨРӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД



ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛИЙН ТОО

 Боловсролын салбар	364	
 Эрүүл мэндийн салбар	105	
 Нийгмийн халамж үйлчилгээ	30	
 Бусад салбар	95	
НИЙТ		594